



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/64

Сант сум

Төсөл сонгон шалгаруулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23. Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Залууст боломж” аймгийн хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйлийн 2.6.2 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм” –ийн 2 дугаар зүйлийн 2.2.2 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.5 дахь Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Сэлэнгэ start up” арга хэмжээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн хөтөлбөрийг сумын хэмжээнд урьдчилсан байдлаар сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

А.Одхүү

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ж.Оюунбат

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Б.Наранцэцэг

(Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангах, шударга өрсөлдөх боломжийг бүрэн хангасан байдлаар сонгон шалгаруулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэгт урьдчилсан байдлаар шалгаруулсан төсөл, бүрдүүлэх материалын хамт танилцуулахыг Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Наранцэцэг)-д үүрэг болгосугай



С.ШИЖИРБААТАР

d/disk 2023 on zahiramj

43151064

Боловсруулсан: *Д. Нарангун*  
Хянасан: *Ч. Амар*  
Хувь: *1*  
Огноо: *2011.05.05*